МАНАЙ СОНИНЫ III УЛИРЛЫН ЗАХИАЛГА ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

MMINFO.

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,090,582.. ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.06.24. Баасан. №128 (4498) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

УЛС ТӨР

НЭР ДЭВШИГЧ З.БАЯНСЭЛЭНГИЙН НЭР ТӨРД ӨРСӨЛДӨГЧ НЬ ХАЛДАЖ ЭХЭЛЖЭЭ

II нүүрт

ШУУРХАЙ МЭДЭЭ

ХОЁР ХУВИЙН БУЦААН ОЛГОЛТЫГ ИРЭХ ЖИЛ ӨГНӨ

VII нүүрт



# Ч.МӨНХЗУЛ: ХАЙР, ХАРУУСАЛ, НЭГ ЦАГТ ДАВХЦАДГААРАА ЭНЭ БАЛЕТ ОНЦЛОГТОЙ

Дэлгэрэнгүй ярилцлагыг V нүүрнээс

Дугаарын 60 мөр

## Ард түмэн тэнэг биш, улстөрчид өө

Б.ӨНӨРТОГТОХ

Ингэж хэлмээр, бухимдмаар зүйл сүүлийн өдрүүдэд олон гарч байна. Монголчууд дөрвөн жилд нэг удаа төрийн эрх барих Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлдэг. Гэвч энэхүү сонголтод нь нөлөөлөх гэсэн явуургүй арга, арчаагаа алдсан үйлдлийг гишүүний суудал горилсон нэр дэвшигчид удаа дараа гаргадаг болоод багагүй хугацаа өнгөрчээ. Уг нь энэ эрхээ монгол түмэн хэний ч оролцоогүй эдлэх оюуны сэтгэхүйтэй, ухаантай. Харамсалтай нь горилогчид дундуур нь орж ирээд элдвийн алиа марзан эвлүүлэг, зураг бичлэг, өрсөлдөгчөө унагах гэсэн явуургүй хар пиар, нэр дэвшигчийн зураг самбарыг урж устгаж тэнэглэх аж. Хууль чанга биш байхад ард түмний саналыг мөнгөөр худалдаж авах гэж улайрдаг байлаа, тэд. Өнөөдөр харин хууль чангарсан учраас самбар урж, эвлүүлэг хийж, хийсэн ажлыг харлуулж л чадаж байгаа юм.

Үргэлжлэл нь III нүүрт

# ХЭН ЮУ ХЭЛЭВ

Н.ПУНЦАГ

### Ж.Батаа: Ам.долларын ханш тогтвортой байна

Нэг хэсэг өсч, 2000 төгрөг даваад байсан ам.долларын ханш бага зэрэг буурч эхлээд байгаа. Зарим эдийн засагчид сонгуультай холбоотойгоор зориудаар буулгаж байна ч гэж хардаад байгаа юм. Тэгвэл ам.долларын ханш яагаад буурч байгаа, цаашид хэрхэх талаар Монголбанкны Зах зээлийн газрын захирал Ж.Батаа ярьжээ. Тэрбээр "Аливаа бүтээгдэхүүн зах зээлд ховор болж эхлэх үед үнэ нь өсч, харин элбэгших үед буурдаг. Яг үүнтэй адил зарчим валютын захад үйлчилж байдаг. Өөрөөр хэлбэл, валютын ханш гэдэг манайд орж, гарч буй валютын тэнцвэрийн илэрхийлэл шүү дээ. Өнөөдрийн байдлаар банкуудын ам.доллар худалдах ханш 1965-1968 төгрөг, Монголбанкнаас зарласан ханш 1961 төгрөгт тус тус хүрээд байна. Энэ нь оны эхнээс 35 орчим төгрөг буюу 1.7 хувь, гуравдугаар сарын сүүлээс 90 орчим төгрөг буюу 4.4 хувиар тус тус чангарсан үзүүлэлттэй байна. Хөвөгч ханшийн дэглэм бүхий манай орны хувьд төгрөгийн ам.доллартай харьцах ханш эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрээр тогтдог. Мөн эдийн засгийн бүтцийн онцлогоос шалтгаалан улирлын шинжтэй өөрчлөлтүүд ажиглагддаг л даа. Тухайлбал жил бүрийн нэгдүгээр улиралд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид сулрах дарамт ирдэг бол хоёрдугаар улирлаас энэ дарамт мэдэгдэхүйц буурдаг.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР







ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# ХАГАС ЗУУНЫГ ЭЛЭЭСЭН 1071 УГСАРМАЛ ОРОН СУУЦЫГ ДУЛААЛНА

Б.ДАВАА

Нийслэлийн хэмжээнд 1960 оноос хойш баригдсан мянга гаруй орон сууц бий гэсэн тооцоо бий. Тэдгээр орон сууцнуудад 45 гаруй мянган өрх амьдардаг гэх ч судалгааны дүн гарсан байдаг. Бүхэл бүтэн хагас зуун жил ашиглагдсан хуучны орон сууцнууд хуучирч муудан өнгө үзэмж нь гундаж, хана, шал, цонхноосоо дулаан алдсаны улмаас иргэд нь өвлийн улиралд гэртээ хэдий ч, гадаа яваа мэт зузаан хувцастай бээрч суух тохиолдол энүүхэнд байсан гээд хэлчихвэл хэдийдэхгүй болов уу. Харин зундаа борооны ус цонх, дээврээр нь гоожиж, СӨХ нь "Гал унтраах" төдийд түр аргацааж өдийг хүрсэн байх юм.



Үргэлжлэл нь II нүүрт

# МОНГОЛ АРДЫН НАМ ХАНДИВЫН ДАНСАА НЭЭЛЭЭ

## "ХААН БАНК" 5115028001 тоот данс

**Иргэн та хандив өргөхдөө**

*Сонгуулийн тухайн хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу:*

*50.1.1 Иргэн гурван сая төгрөг хүртэл /регистерийн дугаар/*

*50.1.2 Хуулийн этгээд арван таван сая төгрөг хүртэл //регистерийн дугаар/*

**Сонгуулийн тухай хуулийн 40.3 д:**

... "Сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийг банкинд нээлгэсэн, сонгуулийн зардлын дансанд энэ хуульд заасан журмын дагуу төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулна" гэсэн.,

заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын дансыг нээсэн тул намын гишүүд, дэмжигчид, дэмжигч байгууллага, иргэд та бүхнийг хандив өргөхийг хүсье.

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1932.00 | 1947.00 | ФУНТ | 2820.00 | 2902.00 |
| ЕВРО | 2173.00 | 2224.00 | РУБЛЬ | 28.10 | 32.00 |
| ИЕН | 18.31 | 18.77 | ЮАНЬ | 293.00 | 296.30 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1937.00 | 1951.00 | ФУНТ | 2830.00 | 2907.00 |
| ЕВРО | 2171.00 | 2231.00 | РУБЛЬ | 28.90 | 31.70 |
| ИЕН | 18.29 | 18.85 | ЮАНЬ | 293.30 | 297.20 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# ҮЗЭЛ БОДОЛ

# ХЭН ЮУ ХЭЛЭВ







**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Өмнөх жилийн мөн үед төгрөгийн ам.доллартай харьцах ханш I улирлын эцсээс 5.1 хувиар чангарч байсан бол 2016 оны II улиралд 4.4 хувиар аажим чангараад байна. Энэ нь дээр дурдсан улирлын нөлөөллөөс гадна Засгийн газар 500.0 сая ам.долларын бонд, 250.0 сая ам.долларын синдикат зээлийг татаж, дотоодын валютын захын нийлүүлэлтийг нэмэгдүүлж, валютын захад оролцогчдын хүлээлтэд нөлөөлснөөр тайлбарлагдаж байна. Оюу толгойн гүний уурхайн санхүүжилт шийдвэрлэгдсэнээр Оюутолгой ХК-ийн үйл ажиллагаа эрчимжиж гадаад гүйлгээний орох урсгал нэмэгдэж байгаа гэсэн шалтгаан бий. Сая дурдсан олон хүчин зүйлээс үүдэж төлбөрийн тэнцлийн энэ оны эхний дөрвөн сарын гүйцэтгэл 202.3 сая ам.долларын эерэг дүнтэй гарлаа. Тодруулж хэлбэл, ингэснээр төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарах суурь нөхцөл бүрдэж байгаа юм" хэмээн ярьжээ.

### А.Гантулга: Бонд орон сууцны үнийг 10.7 хувиар буулгасан

Нэг хэсэг тэнгэрт тулчихаад байсан орон сууцны үнэ сүүлийн жилүүдэд арай л буураад байгаа. Орон сууц үнэ бага буурахад олон хүчин зүйл нөлөөлсөн. Тэр дундаа бондын үр өгөөж багагүй нөлөөлж байгаа талаар ТОСК-ийн Ерөнхий захирал А.Гантулга ярьжээ. Тэрбээр "Орон сууцны үнэ 10.7 хувиар буураад байна. Дөрөв, таван жилийн өмнө орон сууцны үнэ хэд байсан билээ. Тэр үед ямар хүмүүс барилгын салбарт ажиллаж байлаа гээд бодохоор их өөрчлөлт гарсан. Хятадын компаниуд ороод ирчихсэн монголчуудыг дээрэлхдэг, доромжилдог, хэцүүхэн л дүр зурагтай байсан. "Чингис" бондын үр өгөөжөөр Төрийн орон сууцны корпораци байгуулагдлаа. Тэр үеийн орон сууцны үнийн хөөсрөлийг дарлаа. "Буянт-Ухаа 1" хорооллын байрны квадрат метрийн үнэ 1.2 сая төгрөг. "Буянт-Ухаа 2" хорооллын байрны квадрат метр нь сая 350 мянган төгрөгөөр худалдаалагдаж байна. Бид "Чингис" бондоос 277 тэрбум төгрөгийн зээл авсан. Жилийн найман хувийн хүүтэй зээл шүү дээ. Үүнийг бид цаг хугацаанд нь төлөөд явж байна. Бондыг буруу зүйлд үрж байна гэдэг. Үгүй. Иргэд хямд үнээр орон сууцанд орох боломж бүрдсэн. Мөн "Гудамж" төслийг хэрэгжүүлснээр уулзвар, зам өргөтгөж замлаа. Өмнө нь өчнөөн цаг түгжирдэг байхад нэг машин хэдэн литр бензин зарцуулж байсныг монголчууд мэдэж байгаа. Гэтэл өнөөдөр уулзвараар хурдан шуурхай нэвтэрдэг болсон. Аймаг орон нутгуудад "Гудамж" төсөл хэрэгжиж байна шүү дээ. Төрийн орон сууцны корпораци найман аймагт 1000 айлын орон сууц барилаа. "Чингис" бондын ачаар барилгын материалын үйлдвэрүүдээ дэмжлээ, цементээ 100 хувь өөрсдөө хийдэг боллоо. Өнөөдөр Монголдоо байгаа бүтээгдэхүүнээр цемент хийж, монгол хөрсөн дээр байгаа төмрийг хайлуулж барилгын төмөр үйлдвэрлэж байна. Монгол төгрөгөөр монгол ажилчид маань монгол орон сууц бариад иргэддээ худалдаж байна. Энэ бол маш том алхам. Барилгын салбарт хийсэн маш том өгөөж.Өнөөдөр барилга дээр 5000 монгол ажилчид ажиллаж байна. Энэ бол эдийн засаг болон нийгэмдээ хандсан маш том хөрөнгө оруулалт. Бид бондын ачаар гадаадаас барилгын салбартаа хөрөнгө оруулалт авахаар болсон. Бодит зүйл хийсэн улсад ямар ч хүн хүн хөрөнгө оруулахдаа айдаггүй юм байна. 2018 он гэхэд маш том бүтээн байгуулалт өрнөнө. Үлдсэн 3600 айлын байр ашиглалтад орж, хоёр сургууль, цэцэрлэг, спорт заал гээд хотхонд байх бүх л зүйлийг тэнд цогцлооно" хэмээн ярьжээ.

### Д.Бат–Эрдэнэ: Хэвлэлээр дамжуулж иргэдийг сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалж байна

УИХ-ын ээлжит сонгууль болоходцөөнхоногүлдээдбайна. Тэгвэл сонгуулийн ерөнхий хорооноос иргэдийн сонгууль өгөх идэвхийг нэмэгдүүлэх тал дээр ямар үйл ажиллагаа явуулж байгаа талаар. Мөн сонгогчид сонгуулиа өгөхдөө юунд анхаарах талаар Сонгуулийн Ерөнхий хорооны Хууль эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ ярьжээ. Тэрбээр "Нэгдүгээрт, сонгогчдыг мэдээллээр хангах тал дээр нэлээд ажил зохион байгуулж байна. Мэдээллээр хангах бол сонгогчдыг сонгуульд идэвхтэй оролцуулахад хамгийн их үр нөлөөтэй ажил. Тийм болохоор СЕХ –ноос http://songogch.songuuli.gov.mn веб сайт ажиллуулжбайгаа.Тэрсайтаараа дамжуулж 76 тойрогт нэр дэвшч байгаа нэр дэвшигчдийн мэдээллийг хүргэж байна. Мөн дээрээс нь санал авах байрны байршлуулад байгаа. Тухайн сонгогч өөрийнхөө амьдарч байгаа хэсгийнхээ сонгогч мөн үү гэдгийг ч мэдэх боломжтой. Сонгуультай холбоотой зохион байгуулалтын бүхий л шаардагдах мэдээллийг энэ сайт дээр байршуулсан. Дээрээс нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулжиргэдийгсонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалсан сурталчилгаануудыг явуулж байна. Дээрээс нь иргэдэд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ТББ-тай ч хамтарч ажиллаж, сонгогчдыг сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалах чиглэлийн ажлыг ч хийж байна. СЕХ-ноос баталсан загварын дагуу саналын хуудсыг хэвлүүлж дууссан байгаа. Саналын хуудас хоёр хэсгээс бүрдэж байгаа. УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг сонгох хэсэг. Доод талд нь аймгийн юм уу нийслэлийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчийг сонгох хэсэг байж байгаа. Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт ороод, нэг тойрогт нэг мандаттай болсон. Өөрөөр хэлбэл, сонгогчид маань УИХ-ын сонгуульд нэр дэвшигчийг бөглөх хэсэгт зөвхөн нэг л дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг дугуйлна. Нэгээс илүүг дугуйлчихвал саналын хуудас хүчингүй болно. Харин нийслэл болон аймгийн ИТХ-ын сонгуульд өрсөлдөж байгаа нэр дэвшигчийн тухайд бол тухайн тойрогт хэдэн мандат олгогдсон байна тэр тоогоор нь дугуйлж болно. Эсвэл мандатын тооноос дутуу тэмдэглэгээ хийж бас болно шүү дээ. Иргэдийн хурлын сонгуульд гурван мандаттай тойрог байлаа гэж бодъё. Гэтэл тэр тойрогт дэмжихийг хүссэн нэг л нэр дэвшигч байвал түүнийгээ л дугуйлчихаж болно. Өмнө нь энэ тохиолдолд хүчингүй болдог байсан бол одоо тийм биш. Нэг санал чинь тоологдоод л явна. Эсвэл гурван мандаттай байгаа тойрогт гурван хүний нэрийг ч дугуйлж болно гэсэн үг. Магадгүй сонгогчид алдаа гаргаад, илүү тэмдэглэгээ хийчихлээ гэсэн тохиолдолд санал авах байрны ахлах зохион байгуулагчид энэ тухай мэдэгдээд, дахин нэг удаа саналын хуудас авах боломжтой" хэмээн ярьжээ.

Дугаарын 60 мөр

## Ард түмэн тэнэг биш, улстөрчид өө

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Хамгийн эмгэнэлтэй нь эдгээр улс төрийн хүчин, улстөрчид сонгуулийн хар пиартай бидний хүүхэд ахуй, залуу зандан насандаа үзэж бахархаж байсан хуучны сайхан кино, жүжгийг ашиглах болов. Түүнийг нь хошин шогийн хэдэн хамтлаг, продакшны "халтар" жүжигчид амилуулах гэж тамлах нь эмгэнэлтэй. Монгол залуусын сэтгэхүй ухамсар ингэтлээ шинэ зүйлийг сэтгэж чадахгүй болтлоо дампуурсан бололтой юм. Тэр тусмаа хошин шогийнхон. Өмнөх сонгуулиар бид Цогоо гуай гэх "Шинэ үсгийн багш" киноны хэсгийг ханатлаа үзсэн, уйдсан. Өнөө жил ч тэр сурталчилгаа давтагдсаар. Дөрвөн жил өнгөрчихөөд байхад намууд, тэнд ажиллаж буй пиарчид түүнээс илүүг сэтгэж чадаагүй сууж байх юм. Бүтэн хоёр жил Аглуу, Бархүү хоёрын атаархлыг байгууллагуудын сурталчилгаа бүрээс харж ханасан. Өнөө жил ч сонгуулиар нам бүрийн сурталчилгаанаас харав. Өнөөх л Амараа учир утгагүй уурлаж, Аглуу, Бооёо хоёр маазарч буй нийтлэг төрх харагдлаа. Хүний сэтгэхүй минут, секундээр мэдлэг мэдээллийн эрин зуунд шинэчлэгдэж байхад манай залуус, хошин шогийн хамтлагууд шинийг сэдэж, санаачилж чадахгүй байгаа нь эмгэнэлтэй. Өмнөхтэйгээ, өнгөрсөн үетэйгээ өнөөдрийг хүртэл зууралдсаар. Хуучны хэдэн уран бүтээлийг сэглэж л тэд хоолоо олж идэж байгааг худлаа гэж хэлэхгүй л байх. Уран бүтээлчийн оюуны өмчийн хулгай ч энд хэрээс хэтэрч буйг нуугаад яахав. Эс бөгөөс гадны уран бүтээл, гадны пиар дуурайж л улстөрчдийнхөө имижийг бүрдүүлэх нь ичгэвтэр. Одоогоос таван жилийн өмнөх монголчуудын сэтгэхүй, өнөөдрийн монголчуудын аливаад хандах хандлага өөрчлөгдсөн гэдгийг тэд яагаад мэдэхгүй байна вэ. Эс бөгөөс мэдсэн ч биднийг санаатай доромжлоод байгаа хэрэг үү. Яаж ч ядарсан байлаа гээд Аглуу, Бооёо хоёрын маазралыг дагаж намирахдаа бид хүрээгүй байна. Ард түмэн ядуу байлаа ч атаархуу Аглуу, Бархүү хоёроос шалтгаалж сонголтоо өөрчлөхгүй нь тодорхой. Шинэ үеийн залуусын сонголт Хүрлээ, Цогоо гуай хоёроос шалтгаалахгүй болжээ, улстөрчид өө. Үүнийг намууд ч тэр хошин шогийн хэдэн жүжигчид ч тэр ойлгох ёстойсон. Хар муухайгаар хэлбэл, тэд халтуур хийж мөнгө олж буй хүмүүс. Гэвч нийгмийг сэхээрүүлж, гэгээрүүлэх өнөөх үүрэг чинь хэний халаасанд гээгдэж хоцроо вэ хэмээн эрхгүй асуумаар санагдлаа. Хошин урлагийн хэдэн жүжигчдээр арга ядсан сурталчилгаа хийлгэж өрсөлдөхийн оронд бодлого, хөгжлийн тухай яриагаар өрсөлдөөч, намууд аа. Улс орны хэмжээний асуудал ярьж, улсынхаа хөгжил дэвшлийн талаар өрсөлдвөл зүгээрсэн. Өнөө маргаашийн явган хар пиар, авгай хүүхний явуургүй хэрүүлээр төрийг жолоодно гэвэл эндүүрч. Ард түмэн тэнэг биш. Хэн нь тэднийг доромжилж, хэн нь жинхэнээр хөгжил дэвшил рүү удирдах гээд байгааг ялгаж салгахтайгаа болсон. Тиймээс иймэрхүү арга ядсан сурталчилгаа, арчаагүй өрсөлдөөн, хуучны хэдэн киног сэглэж орхисон хөгийн суртачилгаагаа одоо больж үз. Шинийг сэтгэж, шинээр өрсөлдөөч намын пиарчид аа. Эвлүүлэг, элдвийн марзан зүйлд итгэдэг гэнэн монголчууд одоо тун цөөрсөн. Хошин шогийнхон ч гэсэн арай шинэ зүйлийг сэтгэж, шинээр бодож сур. Эс тэгвээс хүүхэд нохойн доог болж, нэр хүндээ нэгмөсөн алдаж гүйцлээ, та бүхэн.




ОНЦЛОХ УЛС ТӨР

## Д.Амарбаясгалан: Хотын даргыг МАН-ын нэр хүндэд халдаж гэж үзэн шүүхэд өглөө

Б.ЭРХЭС

Хотын дарга Э.Бат-Үүл саяхан хэвлэлийн хурал зарлаж, Дэлхийн банкнаас хийсэн тайланг танилцуулсан юм. Ингэхдээ газрыг шударгаар үнэлсэн бол их хэмжээний мөнгийг төсөвт төвлөрүүлэх байсан. Үүний буруутан нь үе үеийн хотын даргаар ажиллаж байсан МАН-ын удирдлагуудтай холбон тайлбарласан билээ. Тэгвэл МАН-ын Нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан тэргүүтэй хүмүүс өчигдөр Тусгаар тогтнолын ордонд мэдээлэл хийж энэхүү тайланг Э.Бат-Үүл дарга захиалж хийлгэсэн хэмээн мэдэгдсэн юм. Тэрбээр, "Дэлхийн банкны тайлангийн талархал гэсэн хэсэгт нь "Э.Бат-Үүл зөвлөмж, удирдлагын дагуу Улаанбаатар хотын засаг захиргааны хамтын ажиллагаанд тулгуурлан энэхүү тайланг гаргасан" хэмээн тов тодорхой бичсэн байдаг" хэмээлээ. Энэ тайланд 2003-2013 оны газрын харилцааг хамруулсан. Гэвч 2003 оны газрын суурь үнэлгээг 2015 оны үнэлгээгээр тооцсон нь улс төрийн зорилготой гэх хардлага төрүүлж байгааг Д.Амарбаясгалан төлөөлөгч онцолж байлаа. Газрын үнэ тарифийг холбогдох яам, сайдын тушаалаар гаргадаг аж. Жишээ нь, 2007 онд холбогдох яам, сайд нь нэг метр квадрат газар 8800 төгрөгөөр тооцох тушаал гаргасан. Харин 2013 онд сайдын тушаал гаргахдаа нэг метр квадратыг 44.000 мянгаар үнэлэхээр болсон. Энэхүү Дэлхийн банкны тайланд нэг метр квадрат газрыг 280.000 төгрөгөөр тооцсон нь бодит байдалд нийцэхгүй байгаа гэнэ. Э.Бат-Үүлийг өөрийн толгой дээрх өвсийг харахгүй байж хүний толгой дээрх хялгасыг шүүмжилж байгаа юм. Хотын дарга Э.Бат-Үүл хүүгийнхээ нэр дээрх "Грандлайн" компанийг "Амгалан" орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэгчээр шалгаруулсан. Энэ нь Монголд хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэд хэдэн хуулийг зөрчиж байна хэмээсэн юм. удаа дараа намын нэр хүндэд халдаж буй Э.Бат-Үүл захирагчийг тэд шүүхэд өгсөн бөгөөд цагдаагийн байгууллагаас энэ хэргийг Чингэлтэй дүүргийн шүүхэд шилжүүлжээ.

ХӨНДӨХ СЭДЭВ

# ИТГЭСЭН ИТГЭЛ "МӨС БОЛОН ХӨЛДӨХӨД"

С.ОГТОРГУЙ

"Улс шиг хөгжиж-Хүн шиг амьдарна"... Ай сайхан уриа... Сайхан үг... Энэ гоё үгэнд монголчууд итгэхийн дээдээр итгэсэн. Зарим нэг нь өөрийгөө эвдэлж итгэсэн. Аймшигтай нь итгэл үзүүлж төрд илгээсэн АН-ынхан ард түмний итгэлийг "цас болон царцаачихсан". Цантаж амжаагүй цонхоор харахын завдалгүй ард түмний нүдийг нь дарж, чихийг нь бөглөж байгаад өөрсдөө далдуур нам хуйвалдаж, сэм идэцгээсэн юм, АН-ынхан. "Ардчилал ялбал ард түмэн сайхан амьдарна" гэж ухуулж явсан хүмүүс өнөөдөр хаачсан бэ? Нүүрээ хийх газаргүй болоод холын Америкийг зорин одов уу. 2012 оны сонгууль ард түмний хувьд том АНдуурсан сонголт байсан нь сүүлийн дөрвөн жилийн дампуурлаас тодорхой харагдана. Хөнжил дотроо хөлөө жийлцсэн эрх баригчдын дайнд ард түмний амьдрал цавчуулаад дууссаныг "Долоон буудлын Должин" эмээгийн амьдрал бэлхнээ нотолно.

Өнгөрсөн дөрвөн жил Монголын ард түмний юу өөрчлөгдсөн бэ... гэсэн асуултад хүн хүн янз бүрээр л хариулах байх. Харин "Амьдрал ч "ахиулан" дордсон шүү" гэж хэлэх хүн олон бий. Өдрийн нэг талхаа өлхөн авчихдаг байсан хүмүүс сүүлдээ гуялаад ч хүчрэхгүй болж байх шиг байна. Өргөн хэрэглээний бүтээгдэхүүн байсан өндөг тансаг хэрэглээ болж хувирсан нь эрх баригчдын гавьяа. Цагаан будаагаар долоон хоногтоо дөрвөн удаа хоол хийж иддэг байсан бол одоо дандаа лапша идэхийг Н.Алтанхуяг үүрэгдсэн. Үүнээсээ болж Н.Алтанхуяг ч огцорсон. Түүний орыг залгаж гарч ирсэн Ч.Сайханбилэг "Хааны зурагтай төгрөгийн ханш чангарна. Ноён ам.долларын үнэ буурна" гэсэн нь Ерөнхий сайд болоод сэтгэлийн хөөрлөөрөө бурсан худал амлалт байсан нь хоёрхон сарын дараа илчлэгдсэн. Өнөөдөр ам.долларын ханш буураад хааны зурагтай төгрөгийн ханш чангарсан юм огтхон ч алга. Харин ч энэ оны эцэс гэхэд 5100 төгрөг давж магадгүй нөхцөл байдал үүсээд байгааг эдийн засагчид онцлон тэмдэглэсээр байна. Ард түмний халаасанд байгаа цөөхөн хэдэн төгрөг нь цаас болон хувирч байгааг эрх баригчид анзаарахгүй байсаар өнөөдөртэй золголоо.

...Одоо ард түмэн АН-д дахиж итгэх итгэл ч алга, сэтгэл ч алга, зүтгэл алга. АН-ын эрээ цээргүй дампууруулсан дөрвөн жилийг арай гэж өнгөрүүлснээ зовлон болгож ярьж суугаа нь эмгэнэл ч юм шиг. Энэ удаа ард түмэн тэдэнд итгэх хөг нь өнгөрсөн...

Монгол Улсын гадаад дахь нэр хүнд унаж, зээлжих зэрэглэл дөрөв дахин буурсны бурууг хэн хүлээх вэ. Дампуурлаа зарлаж магадгүй улсуудын хоёрдугаарт, бүр тодруулбал Зимбабе улсын дараа эрэмбэлэгдэж байгаа бурууг бас хэн хүлээх вэ. Эдгээр асуултын хариуг олж цөхөөд байх юм байхгүй. Сүүлийн дөрвөн жил УИХ-д ямар нам олонхи болж суусан... Засгийн газрыг хэн толгойлж байв гэдгээс хариу нь гараад ирнэ. Үндсэндээ Монгол Улс жолоогүй хадуурсан морь шиг дөрвөн жил давхилаа. АН-д итгэлээ эвдүүлсэн ард түмэнд ахиулан хадуурах тэнхэл ч алга. Нөгөө хэн ч билээ дуучны дуунд гардаг шиг "итгэсэн итгэл нь мөс болон хөлдөж" байна. Одоо ард түмэн АН-д дахиж итгэх итгэл ч алга, сэтгэл ч алга, зүтгэл алга. АН-ын эрээ цээргүй дампууруулсан дөрвөн жилийг арай гэж өнгөрүүлснээ зовлон болгож ярьж суугаа нь эмгэнэл ч юм шиг. Энэ удаа ард түмэн тэдэнд итгэх хөг нь өнгөрсөн. Ахиулан дампуурах гээгүй л юм бол АН-ыг дэмжих хүн Монголд лав олдохгүй.

ЭНТЕРТАЙНМЭНТ

УРАН БҮТЭЭЛЧ

# Ч.Мөнхзул: ХАЙР, ХАРУУСАЛ НЭГ ДООР НЭГ ЦАГТ ДАВХЦАДГААРАА ЭНЭ БАЛЕТ ОНЦЛОГТОЙ

Б.НОМИН

*Улсын дуурь бүжгийн эрдмийн театрын тайзнаа тавигдсан хамгийн анхны мэргэжлийн балет болох ОХУ-ын нэрт хөгжмийн зохиолч Б.Асафьевийн “Бахчисарайн оргилолт булаг” балетын түүхэн 60 жилийн хүндэтгэлийн тоглолт энэ сарын 25, 26-ны өдрүүдэд 17:00 цагаас болох гэж байна. Энэхүү тоглолтын тухай УДБЭТ-ын ерөнхий захирал Ч.Мөнхзултай ярилцлаа.*



**-“Бахчисарайн оргилолт булаг” балетын 60 жилийн хүндэтгэлийн тоглолт болох гэж байна. Уг бүтээлийн агуулгыг товчхон дурьдвал?**

-Гол дүрийн баатар болох Польш бүсгүй Мариягийн төрсөн өдрийн цэнгүүн ид дундаа болж байтал Гирей хааны татар цэргүүд цэцэрлэгийг бүсэлж, нэвтрэн орж, ширүүн тулалдаан болно. Шилтгээнээс Марияа, түүний хайртай залуу Вацлав хоёр гарч зугтаах гэтэл хаан Гирейтэй таардаг. Ингээд хаан Вацлавыг хөнөөдөг. Харин Гирейхаан, Мариягийн толгойноос алчуурыг нь хуу татсанаа бүсгүйн гоо үзэсгэлэнг гайхан зогтусч, дурладаг. Ингээд Марияа Гирей хааны хайртай бүсгүй болж ордонд нь очно. Ордонд Гирей хаанд маш их хайртай Зарема гэх их хатан бий. Тэрээр хайртай хүнээ өөр бүсгүй рүү татагдаж байгааг мэдээд Марияаг хөнөөчихдөг юм. Ингээд Гирей хаан хайртай бүсгүйнхээ дурсгалд зориулж усан оргилуур босгодог. Улмаар өөрийнх нь хайртай бүсгүйг хөнөөсөн ч өөрт нь хязгааргүй хайртай Заремаг өндөр хаднаас түлхэж унагаадаг. Хамгийн сүүлийн үзэгдэлд Гирей хаан гунигтайгаар усан оргилуур дээр бодлогоширон зогсож байгаагаар дуусдаг.

**-Энэхүү балет бусад бүтээлүүдээс юугаараа онцлогтой вэ?**

-Энэ бүтээлийг анх тавьж байхад мэргэжлийн балетчин Монголд байсангүй. Тэр үеийн ахмадууд маань Монголд мэргэжлийн балетыг хөгжүүлнэ гэсэн шийдвэр гаргаж энэхүү бүтээлийг тавьж байлаа. Өөрөөр хэлбэл, “Бахчисарайн оргилолт булаг” анх удаа тавигдсан мэргэжлийн, бүрэн хэмжээний балет гэдгээрээ онцлогтой. Мөн түүхийн улбааг хөөж үзвэл энэхүү бүтээл нь Монголын түүхтэй холбогдоно. Хаан Гирей угтаа монголчууд Крымийг эзэлж байх үед байсан бага хаадын үр сад гэж хэлж болно. Тэгэхээр манай дорнын түүхтэй холбоотой балет гэдгийг хэлэхэд таатай байна. Бас нэг онцлог нь энэ бүтээл өөрөө балет драма буюу жүжиг. Уг балетад тоглож байгаа жүжигчдээс жүжигчний өндөр ур чадвар шаардагддаг. Дүрийнхээ дотоод сэтгэлийг харуулдаг гэх үү дээ. Гирей хааны хайр, харуусал, зэвүүцэл нэгэн доор яг нэг цаг мөчид давхцаж байдаг. Чин зүрхнээсээ хайрлаж, дурласан эмэгтэйг нь өөрийг нь үнэн сэтгэлээсээ хайрладаг бүсгүй хөнөөчихдөг. Ийм нөхөлд өөрийг нь чин сэтгэлээсээ хайрлаж байгаа тэр эмэгтэйг хайрлах уу, жигших үү гэсэн сэтгэл санааны том дотоод зөрчилдөөн үүснэ. Мөн хүн өөрийг нь маш ихээр хайрлаж, дурлаж байхад үл тоох ямар хэцүү байдаг. Тэр хэцүүг даван туулж, үргэлжлүүлэн хайрлах ямар хүнд байдгийн харуулдаг. Хайртай нөхрөө өөр хүн рүү яваад өгч байгааг харж суугаа Заремагийн харуусал, гунигийн ч мөн дүрсэлдэг. Энэ мэт хүний сэтгэлийн хамгийн нарийн нандин зүйл болох хайр сэтгэлийн зөрчлийг энэхүү балетын жүжгээс мэдэрч болно. “Барчисарайн оргилолт булаг” балет маань өөрөө үнэн сэтгэлээсээ, гүн гүнзгий хайрлан дурладаг оргилуун дорнын сэтгэхүйг нэвт шингээж өгсөн. Үүнийг Гүрж бүсгүй Заремагийн дүрээс тодорхой харж болно. Цаазын ял сонсохоос ч айхгүйгээр хайр дурлалын төлөө тэр тэмцдэг. Ийм учраас жүжигчний уран чадварыг онцгой их шаарддаг юм аа. Энэ бүтээл манай театрын тайзнаа 60 жил амьдарлаа. Аливаа бүтээл удаан хугацаанд амьдарч байна гэдэг бүтээлийн хүний сэтгэлд хүрэх, тайзан дээр амьдрах чадвар хэр сайтайг харуулж байгаагийн илрэл. Мөн уран бүтээлчдийг хөглөж, хөгжүүлж, үзэгчдийн сэтгэлд хүрч байгаагийн том баталгаа шүү дээ.

> ...“Барчисарайн оргилолт булаг” балет маань өөрөө үнэн сэтгэлээсээ, гүн гүнзгий хайрлан дурладаг оргилуун дорнын сэтгэхүйг нэвт шингээж өгсөн. Үүнийг Гүрж бүсгүй Заремагийн дүрээс тодорхой харж болно. Цаазын ял сонсохоос ч айхгүйгээр хайр дурлалын төлөө тэр тэмцдэг...

**-Жаран жилийн өмнө анх тайзнаа амилснаас хойш хэдэн удаа шинэчилж тавьсан бэ?**

-Тавилт гэдэг нь тайз засал, хувцаслалт, дэглэлтийн хувьд шинэчлэхийг хэлнэ. “Бахчисарайн оргилолт булаг” балет нийт гурван удаа тавигдсан. Монголд анх 1956 онд А.В.Хабаевийн дэглэлтээр тавигдаж байлаа. Энэ үед тайзны удирдаачаар Ардын жүжигчин Төрийн шагналт Ж.Чулуун, ерөнхий зураачаар Монгол Улсын Төрийн шагналт, Ардын зураач Л.Гаваа нар ажиллаж, гол дүрүүдийг Ц.Тоомой, УГЖ Н.Баатар, УГЖ Дашдулам, УГЗ н.Булхүү, УГЗ Б.Гүрбазар нар бүтээсэн юм. Харин хөгжмийн гоцлолыг УГЗ Д.Цэрэндолгор, виолончель хөгжмийн гоцлолыг Ардын жүжигчин, Төрийн шагналт, Гавьяат жүжигчин Г.Жамъяан нар тоглож байлаа. Үүний дараа 1962 болон 1976 онд шинээр тавигдсан. Нийтдээ 200 гаруй тоглолт өнгөрсөн хугацаанд үзэгчдийн хүртээл болжээ.

**-Энэ удаагийн тоглолтод ямар ямар балетын жүжигчид тоглох гэж байна?**

-Тоглолт маань хоёр өдөр болно. Эхний өдрийн тоглолтод Мариягийн дүрийг УДБЭТ-ын гоцлол бүжигчин МУГЖ Г.Цолмон, Заремагийн дүрийг МУГЖ Ч.Ганчимэг, Бацлавын дүрийг Б.Пүрэв-Очир, харин хаан Гирейн дүрийг ОХУ-ын балетын жүжигчин, Япон улсын балетмейстер багш Г.Валери амилуулна. Харин хийл хөгжмийн гоцлолыг СТА М.Ариунцэцэг, виолончель хөгжмийн гоцлолыг СТА Ц.Ариунаа нар хөгжимдөнө.

**-Манай залуучууд сүүлийн үед сонгодог урлаг, балет, дуурийн тоглолтыг их сонирхох болжээ. Таны хувьд сонгодог урлаг руу юу хөтөлсөн бэ. Залуучуудаа юу гэж уриалмаар байна?**

-Сүүлийн үед балет сонирхож байгаа залуучууд нэмэгдэж байгаад маш таатай байна. Оюутан байхдаа би өглөөний наймаас орой долоо дөч хүртэл хичээлтэй байдаг байлаа л даа. Тэр үед миний хамгийн сайхан амарч, ачааллаа хөнгөлж чаддаг үе театрт ирж бүтээл үзэх байлаа. Би дөрөвдүгээр ангийн сурагч байхаасаа л театрын үзэгч байсан. Долоон паар хичээлийн дараа маргааш балет, дуурь үзнэ гэхээс сэтгэл санааны хувьд урд оройноос нь тайвшрал мэдэрдэг байсан. Театрын хаалгаар оронгуут ер бусын гайхамшигт ертөнцөд очсон юм шиг мэдрэмж авдаг байлаа. Тэгснээрээ дараагийн долоо хоногийн ачаалал надад хүнд биш юм шиг санагддаг байсан л даа. Залуучууд маань өөрийгөө өдөр тутмын амьдрал, үргэлж хийдэг юмнаасаа тасалж, сайхан мэдрэмжийг авахад театр хамгийн их тусална. Тэгэхээр залуучууд маань нэг удаа л орж ирж үзэх ёстой юм байгаа юм. Театрын хаалгаар орж ирэхэд энд тэнд гоё хөгжим дугарч, гоё тоглолт үзэх гэж байгаа хүмүүсийг хараад өдөр тутмын бухимдал алга болчихно. Тэгээд өөрийг чинь өндөр болгочихсон юм шиг, нуруу улам цэхэрч, сэтгэл чинь ер бусын мэдрэмжээр хөтлөгднө. Урлаг өөрөө амьдралын толь шүү дээ. Тайзан дээр байгаа хар санаа, хайр сэтгэл гээд л хүний амьдралын бүхэн байгаа. Гэхдээ маш уран яруу, сэтгэлд таатай хэрнээ ойрхоноор өгүүлж байгаа. Үүнийг нэг л удаа театрт ирээд үзэх хэрэгтэй. Ингээд л хүн энэ мэдрэмжиндээ дурлачихдаг. Байнга л театр руу явах хүсэлтэй болчихдог.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

ӨӨР ӨНЦӨГ

# Н.Энхбаярынханд БАРЬЦААЛАГДСАН ЭРХ БАРИГЧИД

Б.ОРГИЛ

2012 оны наймдугаар сарын 9. Ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан УИХ Монгол Улсын 27 дахь Ерөнхий сайдаар Н.Алтанхуягийг томилов. Түүнийг томилох үеэр гишүүн Ц.Нямдорж “1998 онд Ерөнхий сайд М.Энхсайханы бий болгосон “элсний 13”, 2006 онд Ц.Элбэгдоржийн Засгийн газрыг түлхэж унагасан Ардын намын “элсний 13” хамтран Засгийн газар байгуулах гэж буй нөхдийн дунд байна. Нэг урвасан хүн хоёр дахиа урвадаг юм. Тун удахгүй та нар Н.Алтанхуягийн араас хутга шаачихаад алга болно” гээд эмгэнэл илэрхийлэхийн ялдамд Засгийн газрынх нь насыг асууж байв.

Түүний үг хатуу ч гэсэн үнэн байсныг өнөөдөр бид харж сууна. Н.Алтанхуяг АН-ын түүхэнд хамгийн удаан ажилласан Ерөнхий сайд болсон ч бүрэн засаглаж чадалгүй, хоёр жил, гурван сарын дараа ажлаа өгсөн. Энэ бол засаглаж чаддаггүй АН-ынхны замбараагүй амбиц, эрх мэдлийн төлөөх эх адаггүй тэмцлийн төлөөс нь Н.Алтанхуягаар туг тахьсан явдал байсан.

Бас экс Ерөнхийлөгч Н.Энхбаярт барьцаалуулсан эрх баригчид Н.Алтанхуягийг золиос болгосон юм. 2014 оны аравдугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд, АН-ын дарга Н.Алтанхуяг, МАХН-ын дарга Н.Энхбаяр нар хамтын ажиллагааны гэрээгээ гэв гэнэт шинэчилж, гарын үсэг зурцгаасан нь АН-ынхныг яах аргагүй цочирдуулсан. МАХН-ын “малгай” байсан “Шударга ёс” эвсэлтэй гэхээс илүү Н.Энхбаяртай хийсэн улс төрийн тохиролцоо болохыг улстөрчид, ажиглагчид хэлж байлаа. Үнэхээр ч намынхаа дүрмийг зөрчин байж Н.Энхбаяртай 2024 оныг дуустал хүчин төгөлдөр үйлчлэх хатуу заалт бүхий гэрээ байгуулсан нь түүнд барьцаалуулах зүйлтэй хүн дуусаагүйг нотолсон. Үнэхээр ч гарын үсэг зурсан хамтран ажиллах гэрээнд 2016, 2020 оны УИХ-ын ээлжит сонгуульд АН, МАХН-тай түншлэн оролцох, тэр ч бүү хэл тойрогт нэр дэвшигчдийг “тохиролцох” тухай заалтууд тусгасан нь ил болсон юм.

Харамсалтай нь Н.Алтанхуягаар асуудал дуусаагүй. Дараагийн Засгийн газрын “амь” ч Н.Энхбаярын гарт байсан юм. Шийдлийн Засгийн газрын тэргүүн Ч.Сайханбилэгийг огцруулах санал “амилж”, суудал нь дэнжигнэж эхлэхэд тэрбээр МАХН-ын дарга Н.Энхбаяртай Шадар сайдын сэнтийгээр тохирч байж тогтож үлдсэн гэдэг. Өөрөөр хэлбэл, Ерөнхий сайд огцруулахгүйн тулд Н.Энхбаярт Шадар сайдын суудал амалж, Ц.Оюунбаатарыг Шадар сайдаас нь Эрүүл мэнд, спортын сайд болгох тохироо хийснийг тухайн үед олон эх сурвалж хэлж байсан. Эл шуугианы гол эзэд ч үгүйсгээгүй. “Шударга ёс” эвслийн бүлгийн гурван гишүүн болох Г.Уянга, Л.Цог, О.Баасанхүү нарын санаачилсан Ерөнхий сайдыг огцруулах “хөдөлгөөн” ажиглагчдын таамаглаж байсанчлан хараахан өрнөөгүй ч Ч.Сайханбилэг суудалдаа үлдсэн.

Н.Энхбаярт барьцаалуулсан эрх баригчдын паян үүгээр дуусахгүй. МАХН-ын дарга Н.Энхбаяр ханаж үл цадах шунал, амин хувиа хичээсэн эрх ашигтаа хөтлөгдөн хоёр намын хооронд цаас барьж гүйсээр хоосон хоцорсон нь түүх болон үлдлээ. МАН, МАХН эвсэх, эсэхийг тойрч өрнөсөн үйл явцыг харахад Н.Энхбаяр өдөр ирэх тусам өөртөө итгэлтэй болж, хамтарсан ажлын хэсэгт МАХН-аас тавих болзол яван чангарч ирсэн нь эрхгүй анхаарал татаж буй юм. Ямар сайндаа л ажлын хэсгийн уулзалт болгонд өөрсдөдөө илүү ашигтай санал тавьж ирсэн МАХН-ынхан “Женко” Баттулгыг “Баянгол”-оос баривчлах нь гэх дуулианы дараа бүр ч маадгар болох вэ дээ. Тухайн үед Намбарын хүүд найдвар төрүүлж, итгэл төрүүлсэн хүн нь эрх баригч АН-ын дарга байсан гэдэг. Н.Энхбаярыг тойрон хүрээлэгчид нь МАН-ынхантай ярьж, тохирч буйгаа нооргложх ч амжаагүй байхад тэр ярьж, зөвшилцсөнөө АН-ын даргад хэлж, хоёр Энхболдоос хожил хайж, “биеэ үнэлсэн” юм билээ. “Олонх болгоод өгөөч” хэмээн уйлах нь халаг ярьж, ямар ч хамаагүй аргаар ялалт байгуулахыг хүсэж буй эрх баригч намын дарга МАН, МАХН эвсчихвэл явавч өөдтэй юм болохгүй гэж сэтгэхдээ Н.Энхбаяртай уулзаж, утас цохих бүрт илүү таатай зүйл санал болгосон биз. Тэр нь Н.Энхбаярыг л өршөөх зорилготой гэх нэгэн тогтоолын төслийг гэв гэнэт УИХ-д оруулж ирэн, Байнгын хорооны босго давснаар илэрч болох. Ер нь тэд юу, эсийг ярьж, тохиролцсон байж мэднэ.

Эндээс Н.Энхбаяр гэж ямар аймшигтай хүн болохыг мэдэрч, алхам тутамдаа болгоомжлох ёстойг ухаарч сууна. Н.Энхбаяр хэдий аймшигтай байлаа ч ганцхан хүний барьцаанд орж Засгийн газраа самруулсан эрх баригч, АН-ынхныг өрөвдөнө. Монголын улс төр хэдхэн хүний хэлэлцээ, яриа нэртэй хуйвалдаан, шантаажны талбар, аль нэгнийг нь л хөндөхөд нурж мэдэх хөзрөн байшин шиг болчихож хэмээн гутарна. Эх орон, эн тэргүүний ашиг сонирхлынхоо төлөө чөтгөрт сүнсээ худалдъя гэж хэлж үл зүрхлэх улстөрчид олширч, харин ч болоод л өнгөрөх сонгуулиар сэнтий эзлэх зорилгодоо хөтлөгдөн, хэнтэй ч, юуг ч үгсэн тохирч, хуйвалдан найрч, хүч түрэх байдал газар авч буйд эмгэнэнэ. Аз болоход бидэнд ардчилсан сонголт хийх боломж буйд баярлана.

# ДЭЛХИЙ

## Японы Зөвлөхүүдийн танхимын сонгуулийн сурталчилгаа эхэлжээ

Японы парламентын дээд танхимын сонгууль ирэх сарын 10-нд болно. Тэгвэл өчигдөр тус сонгуулийг угтсан нэр дэвшигчдийн сурталчилгаа албан ёсоор эхэллээ. Японы парламентын дээд танхим нийт 242 гишүүнээс бүрддэг бөгөөд гурван жил тутамд эдгээр хууль тогтоогчийн тэн хагасыг шинэчлэн сонгодог юм. Ингэхдээ 121 гишүүний 73-ыг мажоритар, 48-ийг нь пропорциональ тогтолцооны дагуу тодруулдаг байна. Японы парламентын дээд танхимын энэ оны сонгуульд 387 нэр дэвшигч өрсөлдөж байгаа. Эдгээр нэр дэвшигч ирэх сарын 9-нийг хүртэл 18 өдрийн турш сонгуулийн кампанит ажлаа зохион байгуулна. Нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт Японы эдийн засаг, аюулгүй байдлын хэд хэдэн гол асуудал олны анхаарлыг татаж байгаа. Эдгээрийн дунд Японы Ерөнхий сайд Шинзо Абэгийн “Абэномикс” эдийн засгийн бодлого, өнгөрсөн гуравдугаар сард хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Японы Үндэсний аюулгүй байдлын шинэ хууль зэрэг багтаж байна.

Шинзо Абэгийн тэргүүлдэг Либерал ардчилсан нам парламентын дээд танхимд хамгийн олон буюу 116 суудалтай юм. Тус нам энэ байр сууриа хадгалж, олонх болохын тулд энэ удаагийн сонгуульд 61 суудлыг өөрийн болгох шаардлагатай. Энэ оны сонгууль хэд хэдэн талаараа өмнөх жилүүдийн сонгуулиудаас онцлогтой байна. Тухайлбал, Японы хууль тогтоогчид сонгуулийн эрх бүхий иргэдийн насны доод хязгаарыг 20-иос 18 нас болгон бууруулсан. Ингэснээр Японы 18, 19 настай 2.4 сая иргэн анх удаа сонгуульд оролцох гэж байгаа юм. Мөн сонгуулийн тойргуудыг шинэчлэн хувааж, хүн ам шигүү суурьшсан бүсүүд дэх тойргийг нэмсэн гэдгийг тус улсын эрх баригчид онцолж байна.

## Колумбын Засгийн газар ФАРК-тай гал зогсоох хэлэлцээр хийлээ

Колумбын Засгийн газар болон зүүний үзэлт ФАРК бүлэглэлийн босогчид гал зогсоох хэлэлцээр байгуулснаа өчигдөр зарлалаа. Колумб улсад 1964 оноос хойш өнөөг хүртэл үргэлжилж байгаа хямрал мөргөлдөөнд 220 мянга гаруй хүн амь үрэгдэж, олон сая хүн орон гэрээсээ дайжсан байна. Энэ бүхний эцэст байгуулагдаж байгаа гал зогсоох хэлэлцээр Колумбын иргэний дайн хямралыг эцэслэх, энхийн гэрээ байгуулахад чиглэсэн томоохон дэвшил болохыг олон улсын шинжээчид онцолж байна. Мөн талууд ирэх сарын 20 гэхэд энхийн гэрээг эцэслэн байгуулж, Колумбын хямралд цэг тавихаар төлөвлөж байгаагаа мэдэгдлээ.

Өнөөдөр Колумбын ерөнхийлөгч Хуан Мануэль Сантос болон Колумбын Хувьсгалт зэвсэгт хүчин буюу ФАРК бүлэглэлийн тэргүүн Родриго Лондоно нар Кубын нийслэл Хавана хотод хүрэлцэн очиж, гал зогсоох хэлэлцээрт гарын үсэг зурна. Тус ёслолд НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мун мөн оролцоно гэдгээ мэдэгдээд байна. Үүнээс гадна Колумбын засгийн газар, ФАРК бүлэглэлийн хооронд бараг дөрвөн жил үргэлжилж байгаа энхийн хэлэлцээг санаачлагчид болох Куба, Венесуэл, Чилийн төрийн тэргүүн нар тус ёслолд оролцож магадгүй юм байна.




# Британичууд СОНГОЛТОО хийлээ

Б.ДАВАА

Британичууд өнөөдөр Европын холбоонд үлдэх эсвэл гарах гэсэн хоёр сонголтын аль нэгийг нь сонгоно. Санал хураалт орон нутгийн цагаар өчигдөр 07.00 цагт эхэлж, 22.00 цагт дууссан бөгөөд түүнээс хойш санал тоололго албан ёсоор эхэлсэн байна. Бүх нийтийн санал асуулга сонгуультай адил зармаар явагдаж, нийтдээ 46499537 хүн оролцон өөрсдийн сонголтоо дугуйлна. Үлдэх, эс үлдэх гэсэн хоёр сонголын аль нэгийг дэмжих улс төрийн хүчнүүдийн кампанит ажиллагаа дөрвөн сарын хугацаанд үргэлжилж, гагцхүү өчигдөр тэрхүү мэтгэлцээнд иргэд цэг тавилаа. Их Британийн түүхэн дэх гурав дахь удаагийн бүх нийтийн санал асуулгын явцыг эх орон даяараа Би Би Си агентлаг шууд дамжуулан үзүүлсэн байна. Санал асуулгын хуудас маш энгийн асуулттай. “Та Их Британийн Европын холбоонд гишүүнээр үлдэхийг хүсч байна уу, эсвэл гарахыг дэмжиж байна уу” гэх.

Улмаар нийт санал асуулгад оролцогсдын 50-иас илүү хувийн саналыг авсан хариулт Европын холбоо болоод Их Британийн цаашдын хувь заяаг шийдэх учиртай. Одоогоор орон даяар 382 санал авах байр ажиллаж буй бөгөөд тэд 22.00 цагаас санал тооллогыг эхлүүлжээ. Их Британийн иргэд ЕХ-нд үлдэх болон гарах гэсэн хоёр хоёр сонголтын алийг нь хүссэнийг уншигчиддаа долоо хоногийн тойм дугаартаа хүргэх болно. Харин хамгийн сүүлд явуулсан олон нийтийн санал асуулгад ямар үр дүн гарч байсныг сонирхуулья. Гэхдээ санал асуулга бүр өөр өөр үр дүнг илтгэж байна. Сүүлийн нэг санал асуулгад “Гарах” сонголтыг 45 хувь нь дэмжиж байсан бол “Үлдэх”-ийг 44 нь хувь нь дэмжиж, тэдний зөрүү ердөө ганц хувь байгаа юм. Харин өөр нэг санал асуулгад “Үлдэх”-ийг санал асуулгад оролцогсдын ихэнхи нь дэмжиж, улмаар хоёр сонголтын аль алиныг дэмжих улс төрийн хүчнүүдийн мэтгэлцээн ширүүсэх хандлагатай болсон. Гэхдээ аль ч санал асуулгад 10 орчим хувьд ногдох хүмүүс аль сонголтыг хийх нь шийдээгүй байгаа нь анхаарал татаж байна.

Тэдний сонголтоос Их Британи ямар шийдвэр гаргах нь шалтгаалах юм. Түүнчлэн, үлдэхийг ихэнхдээ залуу үеийнхэн дэмжиж буй ч, тэд санал асуулгад идэвхтэй оролцох эсэх нь тодорхойгүй байгаа аж. Гэхдээ тэд гарах сонголтыг хийвэл, санхүүгийн зах зээлд замбараагүй байдал үүсч, ирээдүйд Европын холбоо зүүн, баруун болон хуваагдах хандлага ажиглагдаж байгааг мэргэжилтнүүд онцолж байгаа юм. Тиймээс ч санал асуулга дэлхий нийтийн анхаарлыг татаж байна. Санал тооллого 22.00 цагаас эхэлж, манай цагаар өнөөдөр үдээс хойш 15.00 цаг гэхэд санал асуулгын дүн бидэнд тодорхой болох учиртай.

## Япон зураачийн модон бар 745 мянган еврогийн үнэд хүрэв

Францын Парис хотноо зохион байгуулагдсан уран зургийг дуудлага худалдаанд Японы Эдогийн үеийн зураач Китагава Утамарогийн бүтээл оролцож, 745 мянган еврогийн үнэ хүрчээ. Модон барын аргаар зурсан уг бүтээл шилдэг зургийн бүтээл дундаа хамгийн өндөр үнэ хүрсэн зураг болжээ. Дуудлага худалдааг “Кристис” компани зохион явуулсан байна. Үүнээс гадна 1794-1795 онд буюу маш богино хугацаанд уран бүтээл туурвисан Тошусай Шараку зураачийн жүжигчин Танимура Торазог зурсан зураг 101 мянган еврогоор зарагдсан бол Утагава Кунимасагийн зурсан кабуки жүжигчин “Ивай Ханширо”-ийн зураг 78680 еврогоор тус тус худалдаалагдсан байна. Энэ өдөр мөн цайны аяга, хүж гэх мэт японы 90 гаруй бүтээгдэхүүн дэлгэгдэн бүгд худалдаалагдаж дуусчээ.



## Пакистаны алдартай дуучин амь үрэгджээ

Пакистаны өмнөд нутгийн Карачи хотод тус улсын хамгийн алдартай дуучдын нэг болох Амжад Сабриг үл таних мотоцикл унасан этгээд буудан хөнөөсөн хэрэг гарчээ. Улмаар цагдаагийн алба хаагчид террорист халдлага хэмээн үзэж, мөрдөн шалгалтын ажлаа эхлүүлсэн байна. Карачи хотын төвийн хөл хөдөлгөөн ихтэй Лиакатабад дүүрэгт хоёр зэвсэгт этгээд дуучны машин руу гал нээсэн гэж цагдаа нар мэдэгдлээ. Сабри эмнэлэгт хүргэгдэх замдаа амьсгал хураажээ. Пакистаны “Талибан” хөдөлгөөн уг халдлагын хариуцлагыг өөртөө хүлээсэн байна. Сабри бол лалын шашны аядуу үзэл болох суфизмтэй холбоотой каввали хэмээх хөгжмийн урсгалын хамгийн алдартай төлөөлөгчдийн нэг байсан юм. Тэрээр шашны дууг орчин үеийн хэв маягт оруулан дуулдаг байжээ. Ингэж дуулахыг Пакистанд олон сая хүн дэмждэг бол хэт давруу үзэлтнүүд таашаадаггүй ажээ. “Талибан” хөдөлгөөнийхөн суфизмыг “буруу номын үзэл” гэж үздэг байна. Талийгаачийн хүргэгдсэн “Аббаси Шахед” эмнэлгийн эмч нарын мэдээлснээр дуучин залууг таван удаа буудсан байснаас гадна хамт явж байсан гэр бүлийнх нь гишүүн хүнд шархаджээ.

## Доналд Трамп: Хиллари Клинтон бол хамгийн аймшигтай авлигач

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Бүгд найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан 70 настай Доналд Трамп, Ардчилсан намаас Төрийн нарийн бичгийн дарга Хиллари Клинтон нар нэр дэвших нь тодорхой болсон. Тэгвэл тэдний өрсөлдөөн эдүгээ ширүүсч, нэг нэг рүүгээ хатуу үг чулуудах болов. Тодруулбал, Нью-Йорк хотын иргэдтэй хийсэн уулзалтынхаа үеэр Доналд Трамп өрсөлдөгч Хиллари Клинтоныг “Хамгийн аймшигтай авлигач байж болзошгүй” гэж тодорхойлжээ. Тэрбээр “Энэ дэлхийд худалч хүн маш олон. Гэхдээ Хиллари Ерөнхийлөгчийн сонгуулийн түүхэн дэх хамгийн авлигач хүн байж магадгүй” гэж хэлсэн нь олон улсын хэвлэл мэдээллийн анхаарлыг татлаа. Үүнээс нэг хоногийн өмнө Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон Доналд Трампын эдийн засгийн бодлогыг шүүмжилж, “Трамп уналт” гэж маш товчоор тодорхойлсны хариу үйлдэл гэж ажиглагчид тайлбарлаж байна. Энэ мэтээр долдугаар сард болох хурлаар намууд нэр дэвшигчдээ зарлахаас өмнө өрсөлдөгчгүй үлдсэн хоёр нэр дэвшигч нэг нэгийнхээ эсрэг мэдэгдлийг хийж, өрсөлдөөн ширүүссээр байна.



# ШУУРХАЙ МЭДЭЭ

## Галын аюулаас таван хүүхэд аварчээ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 22 дугаар хорооны иргэн Г.Түвшинжаргал энэ сарын 17-ны өдөр 15:00 цагийн орчим тус хороонд оршин суудаг иргэн Ө-ийн гэрээс утаа гарч байгаатай таарч, гэрт орж галыг унтраасан байна. Гэрт бага насны таван хүүхэд байжээ. Эдгээр хүүхдүүдийг цахилгаан тогоонд боорцог хайрах гэж байхад нь тогооноос гал гарч гэрийн шал болон унь, дээвэр, туурга шатаж эхэлсэн байна. Энэ үед Г.Түвшинжаргал таарч хүүхдүүдийн амийг аварч, гэрийг бүрэн шатахаас өмнө галыг унтраажээ. Авхаалж самбаа, эрэлхэг зориг гарган гал унтрааж, таван хүүхдийн амь насыг авран хамгаалж, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн тус хорооны оршин суугч Г.Түвшинжаргалд нийслэлийн Онцгой байдлын газрын хамт олноос талархал дэвшүүлж байна. Эцэг, эхчүүд харгалзах хүнгүйгээр бага насны хүүхдүүдийг орхиж явахгүй байхыг мөн анхааруулж байгаа юм.

## ХОЁР ХУВИЙН БУЦААН ОЛГОЛТЫГ ИРЭХ ЖИЛ ӨГНӨ

Н.БАТЗАЯА

*Энэ сарын 19-нд НӨАТ-ын урамшууллын сугалааны 12 дахь удаагийн тохирол шинэчилсэн журмын дагуу болж өндөрлөсөн. 12 дахь удаагийн тохирлын азтануудын шагналын эрхийн бичгийг өчигдөр гардууллаа. Энэ үеэр НӨАТ-ын журмын шинэчлэл болон сугалаатай холбоотой зарим зүйлийг НӨАТУС-ийн захирал Р.Отгонтулга тодрууллаа.*

**-Одоогийн байдлаар хэчнээн хүн азтан болсон бэ?**

-Өнгөрсөн ням гарагт НӨАТ-ын урамшууллын сугалааны 12 дахь удаагийн тохирол явагдаж азтанууд тодруулсан. Энэ удаагийн тохирлоос нийт 9246 хүн азтан боллоо. Тодруулбал, 20 мянган төгрөгийн 8307, 100 мянган төгрөгийн 845, 500 мянган төгрөгийн 82 азтан тодорлоо. Мөн дөрвөн сая төгрөгийн 11 азтан, 20 сая төгрөгийн нэг азтан тодорч, эрхийн бичгээ авч байна. Манай 20 сая төгрөгийн азтан Завхан аймгийн Их-Уул сумын иргэн Б.Авирмэд гэж хүн бий. Ер нь НӨАТ-ын урамшууллын сугалаа явагдаж эхэлснээс хойш нийт 44750 азтан тодорсон.

**-12 дахь удаагийн тохирлын азтануудын мөнгийг хэзээ өгөх вэ?**

-Уг нь журмынхаа дагуу 20 хоногт өгөх ёстой. Гэхдээ бид энэ удаагийн азтанууддаа онцгой боломж олгож байгаа. Удахгүй наадам болох учраас энэ долоо хоногт мөнгийг нь оруулна.

**-НӨАТ-ын журам шинэчлэгдсэн. Журмын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-12 дахь удаагийн тохирол шинэчлэгдсэн журмын дагуу явагдсан. Энэхүү журамд иргэн сугалааны тасалбарыг бүртгүүлэхдээ сугалааны тохирол явагдах өдрийн өмнөх өдрийн 24 цагийн дотор бүртгүүлсэн байхаар өөрчлөлт орсон. Өөрөөр хэлбэл, тухайн сугалаанд оролцогч сугалааны тохирол явагдах өдрийн урьд өдөрт амжиж баримтаа бүртгүүлэх шаардлагатай гэсэн үг. Журамд өөрчлөлт оруулсан шалтгаан гэвэл иргэдийн дунд баримтыг хуурамчаар үйлдэх тохиолдол гарсантай холбоотой. Мөн иргэдийн дунд ч гэсэн ийм санал байсан. Тиймээс иргэдийн санал үндэслэн журамд өөрчлөлт оруулалаа. Тэгэхээр 20 сая төгрөгийн азтан тодорлоо гэж бодохуу араас нь ирж, азтан болсон уу, үгүй юу гэх шаардлагагүй болж байгаа юм. Илүү цэцтэй, ойлгомжтой гэсэн үг.

**-Иргэдийн буцаан олголтыг хэзээ олгох вэ?**

-Шинэчлэгдсэн журамд иргэдэд олгох хоёр хувийн буцаан олголт хэвээрээ байгаа. Иргэд тухайн жилдээ багтан хүссэн үедээ баримтаа бүртгүүлж, буцаан олголтоо авч болно. Харин сугалааны хувьд өөрчлөгдсөн гэдгийг анхаарах хэрэгтэй. Буцаан олголтын мөнгийг 2017 оны нэгдүгээр сард иргэдийн дансанд шилжүүлэхээр хуульчилсан. Энэ хуулийг зохицуулалтын хувьд өөрчлөх ёстой. Мөн Төсвийн тухай хуульд заасан олгох хэлбэрээ өөрчлөх, мөнгөний хэмжээг тогтоох шаардлагатай. Эдгээр асуудлыг шийдвэрлэхийн тулд Гааль татварын байгууллага, Сангийн яам, Мэдээлэл, технологийн төвийн хамтарсан ажлын хэсэг гарсан юм.

Манай ажлын хэсэг буцаан олголттой холбоотой тоо баримт, хууль тогтоомжийн өөрчлөлтийн саналыг Засгийн газрын хурлаар оруулаа. Энэ асуудлыг Засгийн газар дэмжин УИХ-д өргөн дэвшүүлсэн болох одоогийн байдлаар завсарласан байгаа. Хэрвээ энэ хуулиуд батлагдвал иргэд энэ есдүгээр сараас эхлэн буцаан олголтоо авах боломж бүрдэнэ.

**-Иргэд баримтаа хэр идэвхтэй бүртгүүлж байна вэ?**

-Тийм ч их биш. Огцом өсөлт буурсан. Учир нь кассын машиныг суутган төлөгч бус аж ахуйн нэгжүүд кассын машин авах шаардлагагүй гэснээс болж иргэдийн идэвх суларсан. Мөн зарим нэг буруу хандлагууд үүнд нөлөөллөө. Хэдийгээр тийм боловч өнөөдрийн байдлаар 700 мянган айл өрх, түүний цаана 1-2 гишүүн байгаа гэж тооцвол хоёр сая 100 мянга орчим иргэд идэвхтэй баримтаа бүртгүүлж байна. Ер нь өдөрт дунджаар 20 сая баримтын мэдээлэл бүртгэгддэг. Цаашид энэ тоо өсч, 35 сая орчим баримт бүртгүүлнэ гэж тооцоолсон. Үүнтэй холбогдуулан ирэх сарын 1-нээс үйл ажиллагаагаа илүү эрчимжүүлэхээр болсон.

**-Мессэжээр сугалааны баримтаа бүртгүүлэхэд нэгж гүйдэг шүү дээ. Үүнийг зохицуулах ажил хийж байна уу?**

-Үүрэн холбооны операторууд тарифын хөнгөлөлтийг хэрэглэгчийн урамшууллаараа дамжуулан өгдөг. Тухайлбал, үнэгүй 1000 мессэж бичих зэрэг урамшуулал олгодог. Тэр урамшууллыг иргэд авч байгаа. НӨАТ-ын сугалааны бүртгэлд зориулж тусгайлан хөнгөлөлт үзүүлэх боломжгүй гэдгийг бидэнд хэлсэн. Цаашид бид хамтын үйл ажиллагаагаа өргөжүүлэн мессэжээр биш өөрсдийн эккаунт руу оруулж болдог төслийг хэрэгжүүлнэ. Энэхүү технологийн шинэчлэлээ наадмын өмнө танилцуулна.

**-Иргэд цаг тухайд нь баримтаа бүртгүүлдэг. Гэтэл бизнес эрхлэгчид төлбөрийн баримтын мэдээллийг татварын нэгдсэн системд илгээгээгүйгээс зарим иргэд сугалаандаа оролцож чадахгүй байна. Үүнд ямар арга хэмжээ авч байна вэ?**

-Аж ахуйн нэгжүүдийн энэ асуудлыг Гааль татварын ерөнхий газар онцгой анхаарч ажиллаж байгаа. Ирэх сарын 1-нээс эхлэн иргэдийн оролцоотой энэхүү асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэнэ. Мөн хууль, журамд зайлшгүй эргэн харж, өөрчлөх асуудлууд бий. Тухайлбал, НӨАТ суутган төлөх аж ахуйн нэгжүүд кассын машинтай байх эсэх нь тодорхойгүй байдаг. Бид үүнийг хүчлэлгүйгээр илүү бизнесийн зарчимд тулгуурлан шийдэхийг эрэлхийлж байна.

**-Аж ахуйн нэгжийг кассын машинжуулах ажил хэр эрчимтэй явагдаж байгаа вэ. Хэчнээн бизнес эрхлэгч кассын машинтай болсон бэ?**

-Хэвлэх цэгийн тоо 38 мянгад хүрсэн. Энэ бол чамлахааргүй тоо юм. Бид үсчин, гоо сайхан, зах, худалдааны төвүүдийг хэвлэх цэгтэй болгохын төлөө ажиллаж байна. Бид анх 50 мянга орчим хэвлэх цэгийн машинтай болно гэсэн төлөвлөгөөтэй байсан. Гэвч төлөвлөгөөндөө хараахан хүрээгүй байна.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН



*Үндэсний их баяр наамам болоход 20 хүрэхгүй хоногийн хугацаа үлдээд буй. Тэгвэл наадмыг зохион байгуулах комиссынхон өчигдөр Хүй долоон худагт ажиллаж, бэлтгэл ажилтай танилцлаа. Улмаар наадмын зохион байгуулалтын талаар сэтгүүлчдэд мэдээлэл өгсөн юм. Тодруулбал, наадмын өдрүүдэд Хүй долоон худагт Монголд үйлдвэрлэсэн 30 цахилгаан автобус иргэдэд үйлчлэх аж. Энэ нь өнгөрсөн жилийнхээс 15-аар нэмэгдсэн үзүүлэлт юм. Үүнээс гадна автобусны зам дагуу 3000 ам метр явган хүний зам шинээр тавьж, нийслэлийн төсвийн хөрөнгөөр шинээр 3000 сандал авч, нийтдээ 6000 сандалтай болсон бөгөөд үүний 4000-ийг нь Хүй долоон худагт байрлуулах аж. Мөн баяр наадмын өдрүүдэд 6800 орчим цагдаагийн албан хаагч ажиллах юм байна.*

## Даатгалтай хүүхдүүдээр хурдан морь унуулахаар болжээ

Ардын хувьсгалын 95 жилийн ойд зориулсан их баяр наадам болоход 20 хүрэхгүй хоног үлдээд байна. Энэ жилийн хувьд улсын баяр наадмын тэгш ой тохиож байгаа бөгөөд гадаад, дотоодын жуулчид, АСЕМ-ын зочид төлөөлөгчид зэрэг баяр наадмыг үзэж сонирхох хүний тоо нэмэгдэх учраас бэлтгэлийг сайтар хангаж, хариуцлагатай зохион байгуулж ажиллахаар бэлтгэлээ базааж байгаа аж. Хүй долоон худагт худалдаа үйлчилгээ явуулах иргэд Чингэлтэй, Хан-Уул дүүрэг, Төв цэнгэлдэх хүрээлэнд үйчилгээ эрхлэх иргэд, аж ахуйн нэгжүүд бусад дүүргээс зөвшөөрлөө авах юм. Энэ жилийн хувьд нийт 250-280 орчим худалдаа, үйлчилгээний газар ажиллуулах төлөвлөгөөтэй байгаа аж. Хурдан морины салбар хороонооc уяач, унаач хүүхдүүдэд тодорхой санамжуудыг өгч ажиллаж байгаа юм байна. Хүүхдийн төлөө үндэсний газар, Монголын морин спортын уяачдын холбоо хамтран гаргасан стандартын дагуу унаач хүүхдүүдийн хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангуулах тал дээр анхааран ажиллаж, эцэг, эхээс нь зөвшөөрөл авсан, даатгалтай хүүхдүүдээр хурдан морь унуулахаар болжээ.

## Тамхины асуудалд холбогдсон дипломатчийн талаар мэдэгдэл гаргав

Украин улсын Дьяково боомтын хилийн шалган дээр Монгол Улсын хоёр иргэн "Дипломат шуудан" гэх наалт бүхий найман хайрцаг тамхи хилээр нэвтрүүлэхээр завдаж байгаад баригдсан. Гадаад хэргийн яамнаас энэ талаар Будапешт дахь Элчин сайдын яаманд нарийн бичгийн дарга, зөвлөхөөр ажиллаж байсан Д.Дөхөмбаяр уг хэрэгт холбогдсон тухай мэдээлсэн. Тэгвэл Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдын яамнаас энэ үйл явдалтай холбоотойгоор зарим хэвлэлд гарсан ташаа мэдээлэлд тайлбар-мэдэгдэл гаргажээ. Мэдэгдэлд "2016 оны зургадугаар сарын 20-нд Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр монголын дипломат их хэмжээний тамхи зөөж байгаад баригдсан гэсэн мэдээ тархсан байна. Уг хэрэгт холбогдогч хувь хүн нь Монгол Улсаас Бүгд Найрамдах Унгар Улсад суугаа Элчин сайдын яаманд эдийн засгийн зөвлөхөөр 2012-2015 онд ажиллаж байгаад эх орондоо бүр мөсөн буцаж, өндөр насныхаа тэтгэвэрт суусан юм байна. Гэтэл ийм ээн тодорхой, хөндлөнгийн хэргийг Монгол Улсаас Оросын Холбооны Улсад суугаа Элчин сайдын яам, Элчин сайдын нэрхүндэд нялзаан, улс оронд болж буй парламентын сонгуулийн сурталчилгааны кампанит цаг үеийн үйл явдалтай холбон башир зорилго агуулсан мэдээлэл цацаж байгаад харамсаж байна. Болчимгүй, баримт нотолгоогүй ийм мэдээлэл нь хоёр орны харилцаанд ч сэв суулгах уршигтайг зориуд анхааруулан дээрх хэрэгт Москва дахь Элчин сайдын яам учир холбогдолгүй гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдэж байна" хэмээсэн байна.

## Япон улсад ажиллах иргэдийн бүртгэл эхэллээ

"Сайн дадлагажигч" хөтөлбөрийн талаар өчигдөр Хөдөлмөрийн яамнаас мэдээлэл хийлээ. Энэхүү хөтөлбөр нь УИХ-ын даргын Японд хийсэн ажлын айлчлалын үеэр манай улсын Хөдөлмөрийн яам болон Япон улсын Эрүүл мэнд хөдөлмөр, нийгмийн халамжийн яам хооронд байгуулсан "Хөдөлмөрийн салбар дахь хамтын ажиллагааны санамж бичиг"-ийн хүрээнд хэрэгжиж буй юм. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Дадлагажигч ажилтан гадаадад илгээх төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулсан. Уг төв нь Монгол Улсын иргэдийг гадаадын өндөр хөгжилтэй орнуудад дадлагажигч ажилтнаар илгээх, олон улсын байгууллага, гадаадын томоохон нийгэмлэг ажил олгогчтой гэрээ хэлэлцээ байгуулах чиг үүрэгтэй юм. Тэгвэл өчигдрөөс эхлэн Япон улсад ажиллах сонирхолтой иргэдийг аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтэст бүртгэж эхэлсэн байна. Иргэд бүртгүүлэхдээ хоёр хувь цээж зураг, иргэний үнэмлэх, эсвэл гадаад паспорт, мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэхийг эх хувиар нь болон хуулбартай авч очих шаардлагатай. Гэхдээ "Сайн дадлагажигч" хөтөлбөрт хамрагдах залуус тодорхой шаардлага тавигдах гэнэ. Тухайлбал, мэргэжлийн ур чадвартай, япон хэлний мэдлэгтэй, 18-39 насны залуучууд байх ёстой аж.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Зам тээврийн ослын улмаас нэг хүн нас барж, 14 хүн гэмтжээ

Улаанбаатар хотын Замын цагдаагийн ЖШҮХ-т энэ сарын 22-нд нийт 350 дуудлага мэдээлэл хүлээн авснаас зам тээврийн ослын 259 дуудлага бүртгэгдсэн байна. Тухайлбал, 14 хүн хүнд хөнгөн гэмтэж, гурван хүүхэд зам тээврийн осолд өртжээ. Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 76 жолоочийг журамлаж, гарч болзошгүй аюулаас сэргийлсэн талаар Улаанбаатар хотын Замын цагдаагийн газраас мэдээллээ. Түүнчлэн онц ноцтой нэг осол гарсан байна. Тодруулбал, Сүхбаатар дүүргийн Чингэлтэйн өргөн чөлөөнд байрлах "Уянга" караокены урд талын замд "Тоёото аллион" маркийн машины жолооч Б явган зорчигч 55 настай эрэгтэйг мөргөж, амь насыг нь хохироосон хэрэг гарчээ. Хохирогч хэн болох нь одоогийн байдлаар тогтоогдоогүй байгаа ажээ. Тиймээс замын хөдөлгөөнд оролцохдоо анхаарал болгоомжтой байхыг Замын цагдаагийн газраас анхаарууллаа.

# ЗАВСАРЛАГА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## “БӨРТЭ ЧОНО-ТАВАН ЦАГАРИГ” ХӨШӨӨГ ОЛИМПИЙН ХОРООНЫ ӨМНӨХ ТАЛБАЙД БОСГОЛОО





Б.ДАВАА

Олон улсын “Олимпийн өдөр” өчигдөр тохиолоо. Тэртээ 122 жилийн өмнө буюу 1894 оны зургадугаар сарын 23-ны өдөр Францын нийгмийн нэрт зүтгэлтэн Пьер де Кубертин Парис хотын Сорбоны их сургууль дээр хэсэг нөхдийн хамт Олон улсын олимпийн хороо (IOC)-г үүсгэн байгуулж, орчин цагийн олимпийн наадмыг сэргээх түүхэн шийдвэрээ гаргасан байдаг. Түүнээс хойш энэ дурсгалт өдрийг хүн төрөлхтөн “Олон улсын олимпийн өдөр” хэмээн мөнхөлж, жил бүр ОУОХ-ны гишүүн 205 оронд ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлж иржээ. Манай орон ч жил бүр тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Тэгвэл “Олимпийн өдөр”-ийг тохиолдуулан өчигдөр МҮОХ-ны гадна талбайд олимпизмийн үйл хэрэгт нэгдэж буйн илэрхийлэл болгон “Бөртэ чоно-Таван цагариг” хөшөөг МҮОХ-ны өмнөх талбайд сүндэрлүүлэх ёслол хүндэтгэлийн үйл ажиллагаа зохион байгуулагдлаа. Энэхүү ёслолд ОУОХ-ны хүндэт гишүүн, СГЗ Ш.Магван, МҮОХ-ны ерөнхийлөгч Д.Загдсүрэн, 1968 оны Мехикогийн олимпийн болон ДАШТ-ий хүрэл медальт, Ардын багш, гавьяат тамирчин Д.Сэрээтэр, Монреалын олимпийн мөнгөн медальт, Дэлхийн хошой аварга, Хөдөлмөрийн баатар З.Ойдов, Олимпийн аварга, ДАШТ-ий мөнгөн медальт, Хөдөлмөрийн баатар Э.Бадар-Ууган тэргүүтэй спортын алдартнууд, олимпизмийн зүтгэлтнүүд, тамирчид, дасгалжуулагчид болон спорт, олимпизмийг дэмжигчдийн төлөөлөл ирж оролцсон юм. Энэхүү ёслолын үйл ажиллагааг нээж

МҮОХ-ны Ерөнхийлөгч Д.Загдсүрэн үг хэлсэн бөгөөд тэрбээр “Өнөөдөр энэ цагт дэлхийн 206 орон "Олон улсын Олимпийн өдөр"-ийг тэмдэглэж байна. Үүнтэй холбогдуулан бид Олимпийн хорооныхоо өмнөх талбайд Олимпийн медальтнууд, Олимпт оролцогчдоо алдаршуулах зорилгоор "Бөртэ Чоно" шагналын нэрэмжит "Бөртэ-Чоно" хөшөөний нээлтийг өнөөдөр хийж байгаадаа таатай байна” гэв. Энэ жилийн баярын онцлог нь Риогийн зуны олимп хийгээд МҮОХ-ны 60 жилийн ой давхцаж буйгаараа онцлогтой байв.

МҮОХ 1956 онд байгуулагдаж, 1962 онд Олон улсын олимпийн хороонд, 1982 онд Азийн олимпийн зөвлөлд тус тус элсэж, зуны 12, өвлийн 13 наадамд оролцжээ. Олимпийн Харти болон таван цагаригийн дор эвлэлдэн нэгдэж чадсан хүн төрөлхтөн өнгөрсөн хугацаанд энх тайвны бэлгэ тэмдэг болсон олимпийн талбарт шударгаар өрсөлдөж шилдгүүдээ тодруулсаар байна. Тэдгээр тамирчдыг гагцхүү спорт хэмээх ертөнц нэг тэнгэр дор нэгтгэдэг юм. Монголчууд олимпийн хөдөлгөөнд нэгдсэнээс хойш анх удаа 44 жилийн дараа 2008 оны Бээжингийн зуны олимпийн наадмаас анхны олимпийн аварга тамирчдаа өлгийдөн авсан билээ. Түүнчлэн, “Рио-2016” олимпийн наадамд Монголын баг тамирчид түүхэндээ хамгийн олон хүний бүрэлдэхүүнтэй оролцох гэж байгаа юм. Өнөөдрийн байдлаар Монгол Улсаас 40 орчим тамирчин зуны Олимпт оролцох эрхээ авсан гэсэн таатай мэдээлэл ч байна. Ингээд тус үйл ажиллагаанд хүрэлцэн ирсэн зарим тамирчдын сэтгэгдлийн сонирхсон юм. Бидний уулзсан эхний хүн бол Олимпийн аварга, ДАШТ-ий мөнгөн медальт, гавьяат тамирчин Э.Бадар-Ууган байв. Тэрбээр “Юуны өмнө олимпийн наадамд оролцож, эх орныхоо нэрийг дэлхийн дэвжээнд дуурсгаж яваа үе үеийн тамирчдадаа, спортын зүтгэлтнүүддээ баярын мэнд хүргэе. Энэ баярын үеэр “Бөртэ чоно” хөшөөний нээлт болж, тэр тусмаа МҮОХ-ны урд сүндэрлэж буйд их бэлгэшээж байна.

Монголын тамирчдын хувьд хамгийн нэр хүндтэй шагнал бол яах аргагүй “Бөртэ чоно”. Айсуй Риогийн олимпоос олон медаль хүртэж, эх орныхоо төрийн дууллыг эгшиглүүлээрэй гэж ерөөе. Бүх тамирчдадаа амжилт хүсье” гэсэн юм. Харин Олимпийн хүрэл, ДАШТ-ий хошой алт, нэг мөнгөн медальт, гавьяат тамирчин С.Батцэцэг “Өнөөдөр их сайхан нарлаг өдөр болж байна. Олон улсын олимпийн өдөр тамирчид бидний хамгийн их хүсэн хүлээдэг, нэр хүндтэй шагнал болох “Бөртэ чоно” хөшөө нээлтээ хийж байгаа нь баяр дээр баяр нэмлээ. Би “Бөртэ чоно” шагналын эзнээр хоёр удаа тодорсон. Саяхан Европын хоёр цуврал тэмцээнд оролцлоо. Бэлтгэл сайтай, сэтгэл санаа тогтвортой байгаа болохоор өндөр амжилт гаргана гэдэгтээ итгэлтэй байна. Риогийн олимпод өндөр амжилт гаргахын төлөө хичээнэ ээ” хэмээн сэтгэгдлээ хуваалцлаа.




Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +28
Шөнө +13

Нөгөөдөр
Өдөр +24
Шөнө +11

### Өдрийн зурхай

**Аргын тооллын:**
*2016 оны 6-р сарын 24, Баасан гараг*

**Билгийн тооллын:**
*Шинийн 19. Гурван хөх мэнгэтэй Улаагчин үхэр өдөр.*

**Наран ургах/шингэх:**
*05:54 / 21:51*

**Үс засуулбал:**
*Сайн нөхөртэй нөхөрлөнө*



Тухайн өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр эе, эвээ ололцох, хамтын хөдөлмөр эхлэх, гэрээ хэлцэл байгуулах, найр хурим хийх, бэр гуйх, инж өгөх, авах, үнэт эрдэнийн зүйл авах, лус тахих, мал арилжих, гэр бүрэхэд сайн. Цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар явaар одогсод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “Сайн нөхөртэй учирах” хэмээх сайн.

## Рианна юуны учир уйлав

Б.ДАВААХҮҮ

Сүүлийн үед барууны урлаг соёлын алдартнуудын дунд тоглолт дээрээ уйлах мода дэлгэрэв бололтой. Селена Гомез, Жастин Биберээс эхэлсэн энэ мода дуучин Рианнад ч “халдварлав”. Дуучин бүсгүй “Анти” гэх аялан тоглолтынхоо хүрээнд Европыг тойрч буй. Тэрбээр саяхан Ирландын Дублин хотноо тоглолтоо хийж, улмаар уйлан дуугаа ч дуулж чадахаа больсон гэнэ.

Эминемтэй хамтран дуулдаг “Love the Way You Lie” дуугаа дуулах үедээ бүсгүй гэнэт л уйлж, нулимсаа байн байн арчин дуугаа дахин дахин эхлүүлж, сүүлдээ үргэлжлүүлж ч чадахгүй болсон байна. Түүний энэ байдлыг нэгэн шүтэн бишрэгч нь утсандаа буулгаж, сошиалдаа тавьжээ.

Тус бичлэгийг үзсэн хүмүүс “Яагаад уйлж байгаа юм бол”, “Түүнийг уйлахыг харж байгаагүй юм байна” гэх зэргээр санаа тавьж байсан бол Рианна “Хөгжөөн дэмжигчдийн хашгирах дуу нэг танил дуутай адилхан сонсогдоод сэтгэл хөдөлсөн юм. Баярлалаа” хэмээн тайлбар хийсэн аж.